



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/588

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Алтай, Үенч, Манхан, Мөст, Буянт сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулах, Дорнод аймгаас илүү нугаламтай хуц тээвэрлэх тээврийн зардал, Зөвлөгөөнөөс гарсан шийдвэр, сайн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор сонин гаргах зардлын дэмжлэгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5 117 500 төгрөг /Таван сая нэг зуун арван долоон мянга таван зуун/-ийн хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт "Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт"-ын 5.10 дахь "Залуу малчин" дэд хөтөлбөрөөс 3 383 000 төгрөг /Гурван сая гурван зуун наян гурван мянга/-ийг, 5.25 дахь "Залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрөөс 1 734 500 төгрөг /Нэг сая долоон зуун гучин хоёр мянга таван зуун/-ийг тус тус гаргахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax-A/588 Ch  
02 02922

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр  
сарын 13-ны өдрийн А/588 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

| Д.д | Тээврийн хэрэгсэл            | ХНэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Дүн /мян.төг/ |
|-----|------------------------------|-------|------------|-------------------------|---------------|
| 1   | Өргөмжлөл                    | ш     | 105        | 16.500                  | 1 732.5       |
| 2   | Хуц хүргэх тээврийн зардал   | маш   | 1          | 1.500.000               | 1 500.0       |
| 3   | Сонин сэтгүүл бэлтгэх зардал | ш     | 2500       | 754                     | 1 885.0       |
|     | ДҮН                          |       |            |                         | 5 117.5       |

-oOo-